



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хайрхан сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/96/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ж.Мөнгөншагай Утас: 90909190 Цахим хаяг: Mungunshagai.J@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Агуулга

1. Аудитын дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ

 АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 65130 Цэцэрлэг, Архангай аймаг Утас/Факс: 976-70333141 И-мэйл: arkhangai@audit.gov.mn		ХАЙРХАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА О.ЮМЖИРДУЛАМ ТАНАА
2022.02.28	№ 186	
танай	-ны №	-т
Аудитын санал дүгнэлт		
Зөрчилгүй дүгнэлт		
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хайрхан сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Хайрхан сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>		
Дүгнэлтийн үндэслэл		
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>		
Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага		
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p> <p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.</p>		
Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага		
<p>Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.</p>		

Түвшний баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *T. Baygalmaa* Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	651,752.96	528,400.00
2	АВЛАГА	122,852.96	0.00
3	Ажиллагчидтай холбогдсон авлага	122,852.96	0.00
4	БАРАА МАТЕРИАЛ	528,900.00	528,400.00
5	Хангамжийн материал	528,900.00	528,400.00
6	Бичиг хэргийн материал	528,900.00	528,400.00
7	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,958,412.13	23,951,540.17
8	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,958,412.13	23,951,540.17
9	Биет хөрөнгө	3,958,412.13	23,951,540.17
10	Авто-тээврийн хэрэгсэл	0.00	20,500,000.00
11	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,697,268.00	5,408,720.00
12	Хуримтлагдсан элэгдэл	-4,738,855.87	-1,957,179.83
13	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,610,165.09	24,479,940.17
14	НИЙТ ӨР ТӨЛБӨР	100,000.00	0.00
15	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	100,000.00	0.00
16	Өглөг	100,000.00	0.00
17	Бусад өглөг	100,000.00	0.00
18	Байгууллагад төлөх өглөг	100,000.00	0.00
19	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,510,165.09	24,479,940.17
20	Засгийн газрын хувь оролцоо	4,510,165.09	24,479,940.17
21	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,955,000.00	1,955,000.00
22	Хуримтлагдсан үр дүн	1,338,077.19	21,307,852.27
23	Өмнөх үеийн үр дүн	2,075,532.37	1,338,077.19
24	Тайлант үеийн үр дүн	-737,455.18	19,969,775.08
25	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,217,087.90	1,217,087.90
26	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,610,165.09	24,479,940.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	65,601,800.00	85,110,400.00
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	20,500,000.00
3	Нийтлэг татварын бус орлого	0.00	20,500,000.00
4	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	20,500,000.00
5	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	65,601,800.00	64,610,400.00
6	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	420,000.00
7	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	420,000.00
8	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,601,800.00	64,190,400.00
9	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	65,601,800.00	64,190,400.00
10	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	66,339,255.18	65,140,624.92
11	УРСГАЛ ЗАРДАЛ	66,339,255.18	65,140,624.92

12	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,529,415.18	58,515,048.92
13	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	44,791,577.00	44,035,838.00
14	Үндсэн цалин	44,791,577.00	42,355,838.00
15	Гэрээт ажлын хөлс	0.00	1,680,000.00
16	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,760,570.04	5,971,148.96
17	Тэтгэврийн даатгал	3,908,631.61	4,225,993.96
18	Тэтгэмжийн даатгал	464,211.00	441,638.00
19	ҮОМШӨ-ний даатгал	371,368.19	349,950.00
20	Ажилгүйдлийн даатгал	87,936.24	78,687.00
21	Эрүүл мэндийн даатгал	928,423.00	874,880.00
22	Хангамж, бараа материалын зардал	4,576,310.00	2,816,340.00
23	Бичиг хэрэг	1,414,600.00	598,400.00
24	Тээвэр, шатахуун	2,833,410.00	1,952,840.00
25	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,000.00	0.00
26	Ном, хэвлэл	81,000.00	108,000.00
27	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	227,300.00	157,100.00
28	Эд хогшил, урсгал засварын зардал	455,500.00	0.00
29	Урсгал засвар	455,500.00	0.00
30	Томилолт, зочны зардал	198,000.00	242,000.00
31	Дотоод албан томилолт	198,000.00	242,000.00
32	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	108,000.00	0.00
33	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	108,000.00	0.00
34	Бараа үйлчилгээний бусад зардал	6,639,458.14	5,449,721.96
35	Бараа үйлчилгээний бусад зардал	4,903,550.00	3,550,850.00
36	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	975,600.00	1,392,000.00
37	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	760,308.14	506,871.96
38	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,809,840.00	6,625,576.00
39	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	800,000.00
40	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	800,000.00
41	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,809,840.00	5,825,576.00
42	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,809,840.00	5,825,576.00
43	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-737,455.18	19,969,775.08
44	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-737,455.18	19,969,775.08

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,955,000.00	1,217,087.90	1,338,077.19	4,510,165.09
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,955,000.00	1,217,087.90	1,338,077.19	4,510,165.09
3	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	19,969,775.08	19,969,775.08

4	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,955,000.00	1,217,087.90	21,307,852.27	24,479,940.17
---	---------------------------------------	--------------	--------------	---------------	---------------

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	65,601,800.00	64,610,400.00
2	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	65,601,800.00	64,610,400.00
3	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	420,000.00
4	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	420,000.00
5	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65,601,800.00	64,190,400.00
6	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	65,601,800.00	64,190,400.00
7	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,601,800.00	64,610,400.00
8	УРСГАЛ ЗАРДАЛ	65,601,800.00	64,610,400.00
9	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,791,960.00	57,984,824.00
10	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	44,691,985.00	44,135,838.00
11	Үндсэн цалин	44,691,985.00	42,455,838.00
12	Гэрээт ажлын хөлс	0.00	1,680,000.00
13	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,883,015.00	5,848,296.00
14	Тэтгэврийн даатгал	4,085,117.00	4,103,141.00
15	Тэтгэмжийн даатгал	450,000.00	441,638.00
16	ҮОМШӨ-ний даатгал	360,000.00	349,950.00
17	Ажилгүйдлийн даатгал	87,898.00	78,687.00
18	Эрүүл мэндийн даатгал	900,000.00	874,880.00
19	Хангамж, бараа материалын зардал	3,775,660.00	2,815,840.00
20	Бичиг хэрэг	771,100.00	597,900.00
21	Тээвэр, шатахуун	2,619,760.00	1,952,840.00
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,000.00	0.00
23	Ном, хэвлэл	137,500.00	108,000.00
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	227,300.00	157,100.00
25	Томилолт, зочны зардал	198,000.00	242,000.00
26	Дотоод албан томилолт	198,000.00	242,000.00
27	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	108,000.00	0.00
28	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	108,000.00	0.00
29	Бараа үйлчилгээний бусад зардал	7,135,300.00	4,942,850.00

30	Бараа үйлчилгээний бусад зардал	5,572,700.00	3,550,850.00
31	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,562,600.00	1,392,000.00
32	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,809,840.00	6,625,576.00
33	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
34	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00
35	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00
36	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	800,000.00
37	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	800,000.00
38	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,809,840.00	5,825,576.00
39	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,809,840.00	5,825,576.00
40	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
41	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
42	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,190,400.00	58,364,824.00	6,825,576.00	89.5
2	УРСГАЛ ЗАРДАЛ	65,190,400.00	58,364,824.00	6,825,576.00	89.5
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,990,400.00	57,564,824.00	5,425,576.00	91.4
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,680,600.00	44,135,838.00	2,544,762.00	94.5
5	Үндсэн цалин	45,000,600.00	42,455,838.00	2,544,762.00	94.3
6	Гэрээт ажлын хөлс	1,680,000.00	1,680,000.00	0.00	100.0
7	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,195,100.00	5,848,296.00	346,804.00	94.4
8	Тэтгэврийн даатгал	4,395,100.00	4,103,141.00	291,959.00	93.4
9	Тэтгэмжийн даатгал	450,000.00	441,638.00	8,362.00	98.1
10	ҮОМШӨ-ний даатгал	360,000.00	349,950.00	10,050.00	97.2
11	Ажилгүйдлийн даатгал	90,000.00	78,687.00	11,313.00	87.4
12	Эрүүл мэндийн даатгал	900,000.00	874,880.00	25,120.00	97.2
13	Хангамж, бараа материалын зардал	3,405,000.00	2,815,840.00	589,160.00	82.7
14	Бичиг хэрэг	600,000.00	597,900.00	2,100.00	99.7
15	Тээвэр, шатахуун	2,400,000.00	1,952,840.00	447,160.00	81.4
16	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	50,000.00	0.00	50,000.00	0.0
17	Ном, хэвлэл	120,000.00	108,000.00	12,000.00	90.0
18	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	235,000.00	157,100.00	77,900.00	66.9
19	Томилолт, зочны зардал	300,000.00	242,000.00	58,000.00	80.7
20	Дотоод албан томилолт	300,000.00	242,000.00	58,000.00	80.7

21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	200,000.00	0.00	200,000.00	0.0
22	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.00	0.00	200,000.00	0.0
23	Бараа үйлчилгээний бусад зардал	6,209,700.00	4,522,850.00	1,686,850.00	72.8
24	Бараа үйлчилгээний бусад зардал	5,200,000.00	3,550,850.00	1,649,150.00	68.3
25	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,009,700.00	972,000.00	37,700.00	96.3
26	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,200,000.00	800,000.00	1,400,000.00	36.4
27	Бусад урсгал шилжүүлэг	2,200,000.00	800,000.00	1,400,000.00	36.4
28	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,200,000.00	800,000.00	1,400,000.00	36.4
29	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	65,190,400.00	58,364,824.00	6,825,576.00	89.5
30	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	57,390,400.00	58,364,824.00	-974,424.00	101.7
31	Орон нутгийн төсвөөс	65,190,400.00	58,364,824.00	6,825,576.00	89.5
32	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0
33	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
34	АЖИЛЛАГСАДЫН ТОО	2	2	0.00	100.0
35	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
36	Гүйцэтгэх ажилтан	1	1	0.00	100.0
37	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	2	2	0.00	100.0
38	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1	1	0.00	100.0
39	Улс төрийн албан хаагч (УТ)	1	1	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөг /

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	420,000.00
2	УРСГАЛ ЗАРДАЛ	420,000.00
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	420,000.00
4	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	420,000.00
5	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	420,000.00
6	Нэмэлт санхүүжилтийн орлого	420,000.00
7	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	420,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хайрхан сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны хууль тогтоомжийг мөрдөн мэдээллийг хуулинд заасан хугацаанд Шилэн дансаар олон нийтэд мэдээлж хэвшихтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Мөнгөншагай гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хайрхан сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хайрхан сумын ИТХ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-д “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ажлын албатай байна”, 54.2-д “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн санг Засгийн газраас тогтоосон хязгаарын хүрээнд Хурал өөрөө тогтооно”, 54.3-д “Ажлын албаны дарга нь тухайн Хурлын нарийн бичгийн дарга байх бөгөөд орон тооны байна” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэхэд иргэдийн бүтээлч санаачлага, идэвхтэй оролцоо, төлөвлөх эрхийг нэмэгдүүлэн хүний хөгжлийг бүх талаар хангах боломж нөхцлийг бий болгох, нутгийн өөрөө удирдах ёсыг хөгжүүлэх, бие даасан эрхзүйн орчныг бүрдүүлэх”* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын нэгжтэй, санхүүгийн үйл ажиллагаанд 4 чиглэлээр хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хайрхан сумын ИТХ-ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хайрхан сумын ИТХ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 65.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 0.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 20 сая төгрөгөөр өсч материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая.төгрөгөөр/	
			Өөрчлөлт	Хувь
Бараа материал	0.5	0.5	0	0.0
Авлага	0.1		-0.1	-100.0
Үндсэн хөрөнгө	3.9	24.0	20.1	515.4
Нийт хөрөнгө	4.5	24.5	20	444.4
Өр төлбөр	0.1		-0.1	-100.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4.5	24.5	20.0	444.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4.6	24.5	19.9	432.6

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материал 0.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын данс нь 0.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 6.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 6.3 сая төгрөгийн зарцуулалтаар, буурч оны эцэст 0.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Авлага 100 хувь буурсан байна.

Тайлант онд 0.1 сая төгрөгийн авлагыг бүрэн төвлөрүүлсэн байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 20.1 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 3.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд үнэ төлбөргүй 20.5 сая төгрөгөөр нэмэгдсэн бол, байгуулсан 0.5 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 24.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Өр төлбөр 0.1 сая төгрөгөөр буюу 100 хувь буурсан байна.
- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 20.0 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/ сая.төгрөгөөр/
			Өөрчлөлт
0	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт -/орон нутгийн төсөв/	65.6	64.6	-1.0
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		20.5	20.5
Үйл ажиллагааны орлого	65.6	85.1	19.5
Цалин, шимтгэлийн зардал	50.5	49.9	-0.6
Бусад бараа үйлчилгээний зардал	12	8.6	-3.4
Урсгал шилжүүлэг	3.8	6.6	
Үйл ажиллагааны зардал	66.3	65.1	-4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-0.7	20	23.5

Хайрхан сумын ИТХ-ын санхүүгийн үр дүнгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 20.5 сая төгрөгөөр өссөн нь Хайрхан сумын ЗДТГ-аас тээврийн хэрэгсэл үнэ төлбөргүй шилжүүлэн орлого авсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 72.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 14.7 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 57.4 сая төгрөгөөр хянаж баталсан байна. Харин тайлант онд батлагдсан төсөвт тодотгол хийж төсвийг 7.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 65.2 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 65.2 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг 64.2 сая төгрөгөөр авч, 58.4 сая төгрөгийн буюу 89.5 хувийн зарцуулалт хийсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 0.4 сая төгрөгийн орлого төвлөрч сумын ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхижуулах сургалтанд зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 24-ны өдөр Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан ба 2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 8 үндсэн зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 82.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 65.2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 89.5 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд орон тоо нэмэгдүүлээгүй, шагнал урамшуулал олгоогүй, автомашин, албан конторын тавилга, албаны болон дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж хэрэгсэл худалдан аваагүй байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хайрхан сумын ИТХ нь 2021 онд нийт 148 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 132 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулсан бол 16 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дэх заалтыг хэрэгжүүлж, 2022 оны шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол, бүрэн мэдээлэх албан шаардлага хүргүүлэх.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 10% буюу 1.2 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоос 2.9 сая төгрөгийн хэмнэлтийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй бол бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт нь холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төсвийн тухай хуулийн 16.5.2 батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дэх заалтын дагуу хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр оруулж дахин үнэлж холбогдох арга хэмжээг авч ажиллах 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны хуулийн хээгжилтийг авч үзнэ.

-----oOo-----

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
					Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал												
Дүн												
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал												
1	Хайрхан сумын ИТХ	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 16 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан	1							1		
Дүн			1							1		
Нийт дүн			1							1		